




ДЭЭД БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний аудитын газар

2022 оны 6 дугаар сар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын нэр

Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн

Аудитын код

АГГ-2022/21-ШТА-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

Аудитын зорилт

Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэнэ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод нийцүүлэн дээд боловсрол олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн эсэх;
- Дээд боловсролын сургалтын байгууллагын стандарт, сургалт, судалгааны үйл ажиллагаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитад БШУЯ-ны харьяа Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Боловсролын зээлийн сан, Үндэсний статистикийн хороо, ХНХЯ-ны харьяа ХНХСИ, Хөдөлмөрийн бирж болон төрийн өмчийн 20, төрийн бус өмчийн 65, гадаадын их сургуулийн салбар 3, нийт 88 их, дээд сургууль, коллежийн 2019-2022 оны дээд боловсрол олгох үйл ажиллагааг хамруулна.

Үндсэн мэдээлэл

УИХ-аас 2002 онд Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, 2009 онд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, 2011 онд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, 2018 онд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг тус тус баталжээ.

Дээрх хуулиуд батлагдсанаас хойш Боловсролын тухай хуульд 20, Дээд боловсролын тухай хуульд 10, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд 9, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд 6, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд 1 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Дээд боловсролын салбарыг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газрын 2016 оны 178 дугаар тогтоолоор “Орлоготой оюутан”, 2018 оны 282 дугаар тогтоолоор “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөр, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/96 дугаар тушаалаар “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030 он)”-г тус тус баталж, хэрэгжүүлж байна.

Боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна” гэж заажээ.

Монгол Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилийн байдлаар төрийн өмчийн 20, төрийн бус өмчийн 65, гадаадын их сургуулийн салбарын 3, нийт 88 их, дээд сургууль, коллежид 148,954 оюутан суралцаж, 6102 багш ажиллаж байна.

Хүснэгт 1. Дээд боловсролын сургалтын байгууллага (2021-2022 он)

Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт тоо	Дээд боловсролын сургалтын байгууллагын өмчийн хэлбэр			Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал		
	Төрийн өмчийн	Төрийн бус (хувийн) өмчийн	Гадаадын их сургуулийн салбар	Их сургууль	Дээд сургууль	Коллеж
88	20	65	3	38	47	3

Эх сурвалж: БШУЯ

Улсын бүртгэлийн байгууллага боловсролын сургалтын байгууллагыг сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд үндэслэн төрийн өмчийн, ашгийн төлөө бус, ашгийн төлөө гэсэн ангиллаар бүртгэдэг байна.

Засгийн газрын 2018 оны 281 дүгээр тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм”-д боловсролын магадлан итгэмжлэлийн ажиллагааг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл болон сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх байгууллага гүйцэтгэхээр заажээ.

Боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон, ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнадаг байна.

БШУЯ-наас 2021 онд дээд боловсролын хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох хөтөлбөрүүдийг нийгмийн бодит нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн судалгаа, шинжилгээ хийж, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан байна.

Үндэсний аудитын газраас 2016 онд “Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар төрийн өмчийн их, дээд сургуулиудын үйл ажиллагааны стратеги, шинэчлэлийн хөтөлбөрийн үр дүнг үнэлж дүгнэх хяналт сул, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хангалтгүй, сургалтын төлбөрийг тооцох хуулийн шаардлагад нийцсэн журам, аргачлал байхгүй, дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй гэж дүгнэжээ.

Аудитаар БШУ-ны (хуучин нэрээр) сайдад ТӨИДС-д улсын төсвөөс олгох санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэл, эдийн засгийн ач холбогдолд үнэлгээ, дүгнэлт өгч, дээд боловсролын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, хуульд заасан шаардлагад нийцсэн сургалтын төлбөрийг тооцох журам, арга зүйг бий болгож мөрдүүлэх, санхүү, хөрөнгийн нөөцийг ил тод, үр нөлөөтэй зарцуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог нэвтрүүлэх талаар 5 заалт бүхий зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийн талаарх мэдээллийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 2/5382 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд тус аудитаар дээрх асуудлыг нягтлан шалгах болно.

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн үе шатанд судалсан баримт материал, хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн дээд боловсролын өнөөгийн байдал, үр дүнд хийх аудитын ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Аудитын арга зүй

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг баримтлан дээд боловсролын салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж бэлтгэнэ.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

Хууль:

- Боловсролын тухай хууль;
- Дээд боловсролын тухай хууль;
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль;
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль

УИХ-ын тогтоол:

- "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2016 оны 19 дүгээр тогтоол);
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2016 оны 45 дугаар тогтоол);
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (2020 оны 24 дүгээр тогтоол);
- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин" (2020 оны 52 дугаар тогтоол).

Засгийн газрын тогтоол:

- "Орлоготой оюутан" (2016 оны 178 дугаар тогтоол);
- "Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх" үндэсний хөтөлбөр (2018 оны 282 дугаар тогтоол);
- Төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллежийн харьяа сургууль байгуулах журам (2020 оны 132 дугаар тогтоол);
- "Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай" (2021 оны 264 дүгээр тогтоол);
- Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам (2021 оны 275 дугаар тогтоол).

Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал:

- Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030 он (2020 оны А/96 дугаар тушаал);
- Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичгийн загвар, тусгай зөвшөөрлийн загвар (2007 оны 401 дүгээр тушаал);
- Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичгийн загвар, Тусгай зөвшөөрлийн загвар (2010 оны 314 дүгээр тушаал);
- "Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавих нийтлэг шаардлага батлах тухай" (2020 оны А/270 дугаар тушаал);
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Болормаа, Б.Эрдэнэбат, аудитор Г.Жавхлан, Ш.Наранбаатар, Ц.Цолмон, С.Одонцэцэг, Ч.Баярмаа, Ж.Оюунтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

Аудит хийх хугацаа

Аудитын урьдчилсан судалгааны үе шатны ажлыг 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс тус тус эхлэн, аудитын төлөвлөгөөг 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн дотор батлуулж, талбарын үе шатны ажлыг 2022 оны 6 дугаар сарын 28-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлж, зохих үе шатны хяналтаар хянуулсан тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталгаажуулан, 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ХЯНАСАН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЭНХБОЛД

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДОЛГОРСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Б.БОЛОРМАА

АУДИТОР

Г.ЖАВХЛАН

АУДИТОР

Ц.ЦОЛМОН

АУДИТОР

Ш.НАРАНБААТАР

АУДИТОР

Э.УЯНГА

АУДИТОР

Ч.БАЯРМАА

АУДИТОР

С.ОДОНЦЭЦЭГ

2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр